



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хөвсгөл аймгийн асрамж, үйлчилгээний төвийн 2021 оны
жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/191/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Отгонбаяр
Утас: 89306788 Цахим хаяг: otgonbayarde@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|---|----|
| 1. Аудитын санал дүгнэлт..... | 2 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл..... | 3 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 3 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 3 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 5 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 6 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 7 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 8 |
| 3. Аудитын тайлан..... | 9 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 9 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт..... | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 10 |
| 3.4 Материаллаг байдал..... | 10 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 11 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 11 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг..... | 12 |
| 3.8 Аудитын гол асуудал..... | 12 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 13 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... | 13 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 13 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 13 |
| 4. Аудитын илрүүлэлт..... | 13 |
| 4.1 Залруулсан алдаа..... | 14 |
| 4.2 Төлбөрийн акт..... | 14 |
| 4.3 Албан шаардлага..... | 14 |
| 4.1 Зөвлөмж..... | 14 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл..... | 14 |



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/199
танай _____ -ны № _____ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АХМАДЫН
АСРАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА М.САРАНГЭРЭЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ахмадын асрамж, үйлчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Ахмадын асрамж, үйлчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 53,585,476.00 | 72,321,721.24 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 53,585,476.00 | 72,321,721.24 |
| 351 | Түүхий эд материал | 3,000,620.00 | 11,302,724.00 |
| 35130 | Эм боох материал | 3,000,620.00 | 11,302,724.00 |
| 354 | Хангамжийн материал | 50,584,856.00 | 61,018,997.24 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 00.00 | 17,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 29,899,580.00 | 36,498,080.00 |
| 35460 | Хүнсний материал | 11,713,276.00 | 18,932,784.74 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 8,972,000.00 | 5,570,432.50 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 112,733,167.30 | 122,414,791.66 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 112,733,167.30 | 122,414,791.66 |
| 392 | Биет хөрөнгө | 42,424,524.25 | 52,114,791.66 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 65,048,781.00 | 65,048,781.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -25,272,839.28 | -37,909,258.92 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 7,624,900.00 | 31,724,900.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -6,507,428.50 | -7,477,408.34 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 10,190,615.00 | 7,460,615.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -8,659,503.97 | -6,732,837.08 |
| 393 | Биет бус хөрөнгө | 70,308,643.05 | 70,300,000.00 |
| 39301 | Програм хангамж | 992,000.00 | 992,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -983,356.95 | -992,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 70,300,000.00 | 70,300,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 166,318,643.30 | 194,736,512.90 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 166,318,643.30 | 194,736,512.90 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 166,318,643.30 | 194,736,512.90 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 194,236,436.00 | 194,236,436.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 194,236,436.00 | 194,236,436.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -40,740,938.82 | -12,323,069.22 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -40,740,938.82 | -40,740,938.82 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 28,417,869.60 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 12,823,146.12 | 12,823,146.12 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 166,318,643.30 | 194,736,512.90 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 463,485,200.00 | 549,382,980.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 239,500.00 | 26,642,280.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 239,500.00 | 26,642,280.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 239,500.00 | 26,642,280.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 239,500.00 | 26,642,280.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 463,245,700.00 | 522,740,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 27,885,900.00 | 38,522,300.00 |

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 10,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 150,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 27,735,900.00 | 28,522,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 435,359,800.00 | 484,218,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 435,359,800.00 | 484,218,400.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 465,732,422.66 | 514,704,110.40 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 465,732,422.66 | 514,704,110.40 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 459,572,851.39 | 455,976,096.73 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 238,047,100.00 | 238,969,859.94 |
| 210101 | Үндсэн цалин | 238,047,100.00 | 238,969,859.94 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,248,472.73 | 30,753,201.07 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,390,038.92 | 21,454,164.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,344,562.62 | 2,427,663.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,112,532.27 | 1,911,757.34 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 400,917.65 | 450,874.62 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,000,421.26 | 4,508,741.24 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 33,319,400.00 | 34,650,594.12 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,753,710.00 | 8,013,651.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,102,483.00 | 18,383,079.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,463,207.00 | 8,253,863.32 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 22,155,665.00 | 16,014,540.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 746,100.00 | 802,290.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,463,400.00 | 928,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 446,365.00 | 358,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 187,000.00 | 198,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 16,312,800.00 | 13,727,750.00 |
| 2105 | Нормативт зардал | 119,740,709.28 | 108,359,275.96 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,594,938.00 | 6,842,986.00 |
| 210502 | Хоол, хүнс | 98,967,471.28 | 85,847,672.46 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 15,178,300.00 | 15,668,617.50 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,038,100.00 | 10,491,110.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,038,100.00 | 10,491,110.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 90,000.00 | 100,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 90,000.00 | 100,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,269,100.00 | 2,219,140.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 640,000.00 | 1,844,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 451,000.00 | 346,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 28,100.00 | 28,140.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,664,304.38 | 14,418,375.64 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 14,664,304.38 | 14,418,375.64 |

| | | | |
|--------|---|----------------------|----------------------|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6,159,571.27 | 58,728,013.67 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,036,000.00 | 58,316,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 55,211,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,036,000.00 | 3,105,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 123,571.27 | 411,813.67 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 123,571.27 | 411,813.67 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -2,247,222.66 | 34,678,869.60 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 4,616,000.14 | 6,261,000.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -4,616,000.14 | -6,261,000.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -6,863,222.80 | 28,417,869.60 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---|---------------------------------|-----------------------|-------------------|-------|---|
| C01 | 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 123,936,436.00 | 3,210,167.00 | 28,149,916.88 | 00.00 | 98,996,686.12 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 123,936,436.00 | 3,210,167.00 | 28,149,916.88 | 00.00 | 98,996,686.12 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 4,532,032.75 | 00.00 | 4,532,032.75 |
| C08 | 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 194,236,436.00 | 12,823,146.12 | 40,740,938.82 | 00.00 | 166,318,643.30 |
| D01 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 194,236,436.00 | 12,823,146.12 | 40,740,938.82 | 00.00 | 166,318,643.30 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 194,236,436.00 | 12,823,146.12 | 40,740,938.82 | 00.00 | 166,318,643.30 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 28,417,869.60 | 00.00 | 28,417,869.60 |
| D09 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 194,236,436.00 | 12,823,146.12 | 12,323,069.22 | 00.00 | 194,736,512.90 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 463,140,700.00 | 522,740,700.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 463,140,700.00 | 522,740,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 27,780,900.00 | 38,522,300.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 10,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 150,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 27,630,900.00 | 28,522,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 435,359,800.00 | 484,218,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 435,359,800.00 | 484,218,400.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 463,140,700.00 | 522,740,700.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 463,140,700.00 | 522,740,700.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 457,086,128.73 | 464,012,686.33 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 238,047,100.00 | 238,969,859.94 |
| 210101 | Үндсэн цалин | 238,047,100.00 | 238,969,859.94 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,248,472.73 | 30,753,201.07 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,331,612.74 | 21,454,164.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,402,988.79 | 2,427,663.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,112,532.28 | 1,911,757.34 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 400,917.66 | 450,874.62 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,000,421.26 | 4,508,741.24 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 33,319,400.00 | 34,650,594.12 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,753,710.00 | 8,013,651.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,102,483.00 | 18,383,079.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,463,207.00 | 8,253,863.32 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 24,103,665.00 | 15,963,940.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 746,100.00 | 819,990.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,463,400.00 | 668,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 446,365.00 | 358,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 187,000.00 | 198,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,260,800.00 | 13,919,450.00 |
| 2105 | Нормативт зардал | 125,201,321.00 | 119,913,941.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,701,660.00 | 13,711,990.00 |
| 210502 | Хоол, хүнс | 101,999,661.00 | 92,999,901.20 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 17,500,000.00 | 13,202,050.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,807,070.00 | 17,165,110.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,669,800.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 3,099,170.00 | 6,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,038,100.00 | 11,165,110.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 90,000.00 | 100,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 90,000.00 | 100,000.00 |

| | | | |
|-------------|--|---------------------|----------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,269,100.00 | 6,496,040.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 640,000.00 | 6,121,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 451,000.00 | 346,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 28,100.00 | 28,140.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6,054,571.27 | 58,728,013.67 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,036,000.00 | 58,316,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 55,211,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,036,000.00 | 3,105,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 18,571.27 | 411,813.67 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,571.27 | 411,813.67 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|-----------------------|---|-----------------------|---------------|-----------|-------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 484,218,400.0 | 483,806,586.3 | 411,813.7 | 99.9 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 484,218,400.0 | 483,806,586.3 | 411,813.7 | 99.9 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 429,007,200.0 | 428,595,386.3 | 411,813.7 | 99.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 238,975,400.0 | 238,969,859.9 | 5,540.1 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 238,975,400.0 | 238,969,859.9 | 5,540.1 | 100.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 31,126,800.0 | 30,753,201.1 | 373,598.9 | 98.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,607,700.0 | 21,454,164.1 | 153,535.9 | 99.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,379,800.0 | 2,427,663.8 | -47,863.8 | 102.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,903,800.0 | 1,911,757.3 | -7,957.3 | 100.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 476,000.0 | 450,874.6 | 25,125.4 | 94.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,759,500.0 | 4,508,741.2 | 250,758.8 | 94.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 34,651,100.0 | 34,650,594.1 | 505.9 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,419,800.0 | 8,013,651.0 | 406,149.0 | 95.2 |
| 210302 | Түлш, халаалт | 18,231,300.0 | 18,383,079.8 | 151,779.8 | 100.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,000,000.0 | 8,253,863.3 | 253,863.3 | 103.2 |

| | | | | | |
|-------------|--|---------------|---------------|-----------|-------|
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 11,005,200.0 | 10,973,240.0 | 31,960.0 | 99.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 820,000.0 | 819,990.0 | 10.0 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 668,200.0 | 668,200.0 | 00.0 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 358,200.0 | 358,200.0 | 00.0 | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 230,000.0 | 198,100.0 | 31,900.0 | 86.1 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,928,800.0 | 8,928,750.0 | 50.0 | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 107,170,700.0 | 107,170,551.2 | 148.8 | 100.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 968,600.0 | 968,600.0 | 00.0 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 93,000,000.0 | 92,999,901.2 | 98.8 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 13,202,100.0 | 13,202,050.0 | 50.0 | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 781,900.0 | 781,900.0 | 00.0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 781,900.0 | 781,900.0 | 00.0 | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 100,000.0 | 100,000.0 | 00.0 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 100,000.0 | 100,000.0 | 00.0 | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,196,100.0 | 5,196,040.0 | 60.0 | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,821,400.0 | 4,821,400.0 | 00.0 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 346,500.0 | 346,500.0 | 00.0 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 28,200.0 | 28,140.0 | 60.0 | 99.8 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 55,211,200.0 | 55,211,200.0 | 00.0 | 100.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 55,211,200.0 | 55,211,200.0 | 00.0 | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 55,211,200.0 | 55,211,200.0 | 00.0 | 100.0 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 484,218,400.0 | 483,806,586.3 | 411,813.7 | 99.9 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 484,218,400.0 | 483,806,586.3 | 411,813.7 | 99.9 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 484,218,400.0 | 483,806,586.3 | 411,813.7 | 99.9 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 26 | 26 | 0.0 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.0 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9 | 9 | 0.0 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16 | 16 | 0.0 | 100.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|---|----------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 38,522,300.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 38,522,300.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 35,417,300.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,990,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,990,700.00 |

| | | |
|--------|---|---------------|
| 2105 | Нормативт зардал | 12,743,390.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,743,390.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 16,383,210.00 |
| 210602 | Тавилга | 6,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,383,210.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,300,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,300,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,105,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,105,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,105,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 38,522,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 38,522,300.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 28,522,300.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд Хөвсгөл аймгийн Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн Засгийн газрын 43 дугаар тогтоолын, Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Отгонбаяр гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Д.Отгонбаяр, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төв нь Төрийн төрөлжсөн асрамж, үйлчилгээг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх зорилгыг хэрэгжүүлж ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулах бодлого чиглэл өөрчлөлт ороогүй байна. Харин санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг зарим журам, зааварт дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн баталсан байна.
2. Хөдөлмөр нийгэм хамгааллын сайдын 2021 оны А/182 тоот тушаалаар “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан илгээх, хүлээн авах, хянах, баталгаажуулах журам”-ыг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын даргын 2019 оны А/08 тоот тушаалаар баталсан бодлогын баримт бичгийг батлан мөрдөж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн.

Тус байгууллагад тайлант онд хөндлөнгийн хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 465.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28.4 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | /сая төгрөгөөр/ | |
|---|----------------|-----------------|-------------|
| | | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Урьдчилгаа | | | - |
| Бараа материал | 53.6 | 72.3 | 18.7 |
| Үндсэн хөрөнгө | 112.7 | 122.4 | 9.7 |
| Нийт хөрөнгө | 166.3 | 194.7 | 28.4 |
| Өр төлбөр | 0.0 | 0.0 | (0) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 194.2 | 194.2 | 0 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 166.3 | 194.7 | 28.4 |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх он болон тайлант онд үлдэгдэлгүй байна.

Авлага дансны эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 72.3 сая төгрөг болж 18.7 сая төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор бэлтгэсэн материалын нөөц өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 122.4 сая төгрөг болж 9.7 сая төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн данс нь үнэ төлбөргүй хүлээн авсан 24.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, актаар 2.7 сая төгрөгний хөрөнгө актлаж, тайлант үеийн элэгдлийн зардал 14.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 0.0 сая төгрөг болж төлж барагдуулсан 0.0 сая төгрөгөөр буурсан ба өр төлбөргүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 194.2 сая төгрөг байна, тайлант үеийн үр дүн 28.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2021 онд Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 484.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 484.2 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 483.8 сая төгрөгийг зарцуулж 0.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 483.8 сая төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Тухайн байгууллагын төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр харуулбал:

Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээгээр

| № | Арга хэмжээний код, нэр | Зардлын дүн | сая.төгрөг |
|---|-------------------------|-------------|------------|
| | | | Зөрүү |
| | | | |

| | Хөтөлбөрийн код, нэр | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
|-----------------|-----------------------|-------------------------------------|--------------|--------------|------------|
| 1 | 71902 Нийгмийн халамж | 80101 Үндсэн үйл ажиллагаа | 424.2 | 423.8 | 0.4 |
| | | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж | 55.2 | 55.2 | 0 |
| | | 81103 Эрсдлийн сангийн нөөц хөрөнгө | 4.8 | 4.8 | 0 |
| Нийт дүн | | | 484.2 | 483.8 | 0.4 |

Тухайн онд 484.2 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 483.8 сая төгрөгийг зарцуулж 0.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

3.6.3 Нэмэлт төсөв

Нэмэлт зарцуулалтын 100170017401 тоот дансанд нийт 38.5 сая төгрөгний орлого орсон байна. Үүнээс 10.0 сая төгрөг нь Аймгийн ЗДТГ-аас хуваарилсан төсөв, 28.3 төгрөг нь асруулагчдын тэтгэвэр тэтгэмжийн 30 хувийн мөнгө, үлдсэн 160.0 мянган төгрөг нь өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрээр акталсан хөрөнгийг худалдан борлуулсны төлбөр. Асруулагчдын тэтгэвэр тэтгэмжийн 30%-ийн мөнгийг энэ дансанд төвлөрүүлдэг бөгөөд зарцуулалтыг ХАХНХ-ын сайдын 2013 оны 10-р сарын 18-ны А/156 дугаар тушаалын хавсралт “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журам”-ын 3.1.-д заасны дагуу хийдэг. Үүнд:

1. Эм бэлдмэл, эмнэлэгийн багаж хэрэгсэлд 5.6 сая төгрөг зарцуулсан. 3.1.1-3.1.5 дахь заалт
 2. Асруулагчдын амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор ахуйн хэрэглээний техник, төхөөрөмж авахад 21.8 сая төгрөг зарцуулсан. 3.1.8,3.1.10 дахь заалт
 3. Баяр ёслол тэмдэглэлт өдрүүдэд бэлэг 1.1 төгрөг зарцуулсан байна. 3.1.6 дахь заалт /Зарцуулалтыг хуулийн заалт бүрээр харууллаа.
- Засаг даргын нөөц хөрөнгөнөөс хуваарилсан нэмэлт төсвийг удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн дараах зардлуудад Төвийн даргын 2021 оны 12 сарын 20 –ны №А/39 тоот тушаалын дагуу зарцуулсан.
1. Короно вирус өвчний улмаас байгууллагад тусгаарлагдан ажилласан ажилчдад 2.0 сая төгрөгийг тэтгэмж болгон олгосон.
 2. Тусгаарлах өрөө засварлахад 0.8 сая төгрөгийг зарцуулсан.
 3. Эм тариа, эмнэлэгийн багаж хэрэгсэлд 7.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал:

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт иргэн Ц.Баярсайханы 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн өргөдлийн дагуу тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайланд хамааралтай бүтэц орон тоо, цалин тогтоолт, цалингийн нэмэгдэл, урамшуулал болон бараа материал дансны үлдэгдэлд тулгалт хийн тушаал шийдвэрийг хянаж үзэхэд асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу Төсвийн тухай хуулийн 25.5-д заасан тохиолдолд хандив тусламж авсан эсэх, Өндөр настны тэтгэвэр тогтоолгосон ажилтны оронд нөхөн томилгоо хийсэн эсэх асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайлагнахаар энэхүү төлөвлөгөөнд тусгасан.

Хөвсгөл аймгийн Ахмадын асрамж үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтмол зардал, шатахуун, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бараа материал, үндсэн хөрөнгө дансдыг түүвэрлэн үзэж горим сорил хэрэгжүүлсэн.

Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар хянаж үзэхэд дараах асуудал илэрлээ. Үүнд:

Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтны байранд нөхөн томилгоо хийж, цалингийн зардал хэмнээгүй нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.2-т *"Шинээр ажлын чиг үүрэг, тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх"*, Аймгийн Санхүү, Төрийн сангийн даргын 2021 оны 04 сарын 21-ний өдрийн 8/907 тоот албан бичгийн хэрэгжилттэй нийцэхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээллэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн нийт мэдээлбэл зохих 492.2 сая төгрөгийн 65 мэдээллээс 430.0 сая төгрөгийн 61 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ 62.2 сая төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроосон нь шилэн дансны тухай хуулийн 6.1.5, 6.4.5 дугаар заалтууд, МУЕА-ын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан чиглэлтэй нийцэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагаатай холбоотой баримтыг санхүүгийн тайлангийн аудитаар хянан үзээгүй болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хянаж үзэхэд зөвлөмжийн хэрэгжилтийг биелүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц зүйл байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 62.2 сая төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 62.2 сая төгрөгт 2 зөвлөмжийг өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулга хийгээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөх саналын хариу тайлбартай танилцаж, зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. *Илрүүлэлт:* Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 492.2 сая төгрөгийн 65 мэдээллээс 430.0 сая төгрөгийн 61 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, цалингийн зардлаас бусад 62.2 сая төгрөгийн зарлагын 4 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

1.2. *Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ"-т заасан мэдээллийг тухай бүр шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлж байх.

2.2 *Өгсөн зөвлөмж:* Тайлант онд батлагдсан төсвийн талаар баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|--|----------------------|------|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хөвсгөл аймгийн Ахмадын асрамж, үйлчилгээний төв | 2 | 62.2 | | | | | | | 2 | 62.2 |

БАТАЛГААЖУУЛАЛТ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР

Д.ОТГОНБАЯР ОГНОО:

Байгууллагын нэр: Ахмадын асрамж үйлчилгээний төв
Тайланг хугацаа: 2021 оны Санхүүгийн тайлангийн аудит

22.02.07

АУДИТАР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУЛДЫН БҮРТЭЭЛ

| № | Ажилт үйлчилгээний өнцөг, давсны үлдэгдэл | Алдаа зарчгийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллага ас гаргасан шийдэл | Шалгалдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллага өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Төгрөгөөр | | | |
|---|---|---|---------------|--|--|--|-----------------|--------------|-----------------------|-----------------------|-----------------------|
| | | | | | | | | Албан тушаал | Овог чэр | | |
| 1 | Төсвийн зарцуулалт | Өндөр насны тэтгэвэр тогтоолгоосон амжилтын байрванд нөхөн томилгоо хийсэн нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.2-г Шинээр ажлын чиг үүрэг, тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоологч чөлөөтөгдсөн амжилтан, албан тушаалтны орон тоог цэрцрааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цаалигийн зардлыг хэмнэх гэсэн зөвлөлийн хэлэлцээний үндсэн дээр 2021 оны 04 сарын 21-ний өдрийн 8/907 тоот албан ёслын хэрэгжилттэй нийцэхгүй байна. | | Албан шаардлага өгөх | 43 дугаар тогтоолын 1.2 дахь заалтан дээр Шинээр ажлын чиг үүрэг албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоологч чөлөөтөгдсөн амжилтан, албан тушаалтны орон тоог цэрцрааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цаалигийн зардлыг хэмнэх гэсэн зөвлөлийн хэлэлцээний үндсэн дээр 2021 оны 04 сарын 21-ний өдрийн 8/907 тоот албан ёслын хэрэгжилттэй нийцэхгүй байна. Энэ нь манай байгууллага ахмад болон хөгжлийн баршлагатай иргэдийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээг үзүүлдэгтэй холбоотой юм. Хэрэв эзлэгийн амжилтан байхгүй бол ахмад настай асруулагчид асрах хүнтэй болж манай байгууллагын үйл ажиллагаа дотоодод орох эрсдэлтэй. Асрагч амжилтан болон эзлэгийн тогтоол нар 8, 16 цагаар төсрөлгөү, залжээ асруулагч нарыг асрах, хооллох зэрэг тухай хууль зарчигдах асуудал гарч байна. Иймд тэтгэвэрт гарсан тогтоол-1ш, угалч-1ш, асрагч-2ш хүний оронд хүн авч ажиллуулах зайлшгүй шаардлагатай байсан. Мөн короновируссын халдвар авсан аль болгоо хэмнэлт хийн ажилласан байгаа. Эзлэгийн амжилтад 2,3 аргаар ковид тусан хөдөлмөрийн чадвараа алдах үед өвдсөн амжилтанд цаалинг нь бүрэн өгөх, гэтэл оронд нь амжиллах хүн авч ажиллуулах гэжээ цаалигийн сан хүрэлцэхгүй тийм учир байгууллагын үйлдлийн түвшинд зохион байгуулалт хийн амжилтгүй эдгээртэй ажлын байрны дээрээ байрлах амжиллах хүртэл арга хэмжээг авч амжилтанд байгаа. | Иймд манай байгууллагын зүгээс Монгол улсын засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн үр бүтээлтэй амжилтанд хүргэх гэж үзэж байна. | | | | Дарга, Нягтлан бодогч | М.Сарант эрэл Д.Орхон |
| 2 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зардлын гүйцэтгэл 82.2 сая төгрөгийн 4 мэдээллийг хураацаа хоцроосон нь шилэн дансны тухай хуулийн 6.1.5, 6.4.5 дугаар заалтууд, МУЕА-ын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан чиглэлтэй нийцэхгүй байна. | 82,217,200.00 | Зөвлөмж өгөх | Корона вируссын халдвар авсан учраас мэдээллийг хоцроон мэдүүлсэн болно. Дээр цаалинд анхааран амжиллах болно. | | | | Дарга, Нягтлан бодогч | М.Сарант эрэл Д.Орхон | |



БЭЛГТЭСЭН:
АХЛАХ АУДИТОР
ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН: АХМАДЫН АСРАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА
ДОТОНБААР
Э БАТ-ЭРДЭНЭ
ОНОО:

НЯГТЛАН БОДГОГЧ:
ОНОО:
М.САРАНТ-ЭРЭЛ
Д.ОРХОН